



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 1/262

Номгон

Г

Г

Төрөлжсөн ахлах сургууль
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, Монгол Улсын Их хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.2.2.3 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны "Төрөлжсөн ахлах сургууль байгуулах тухай" 11/15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын газраас 2026 оны 04 дүгээр сарын 29-нд албан бичгээр ирүүлсэн санал, дүгнэлтэд үндэслэн Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого Сейкео сургуулийг төрөлжсөн ахлах сургууль болгон өөрчилсүгэй.

2.Бэлтгэл ажлыг хангах зорилгоор ажлын хэсэг байгуулж, төрөлжсөн ахлах сургуулийн хэв шинжид шилжүүлэх, эцэг эх, олон нийтэд мэдээлэл хүргэх, ойлголцол бий болгох ажлыг үе шаттай зохион байгуулж ажиллахыг Соого Сейкео сургууль (Д.Цэдэнсодном)-д, Боловсролын газар (Л.Аюурзана)-т тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т үүрэг болгосугай.



626010701